


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2020 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 2,073.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2,349.8 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 276.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 470.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацааны алдагдал төлөвлөсөн дүнгээс 940.5 тэрбум төгрөгөөр буурч сайжирчээ.

График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/



2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр нийт тэнцвэржүүлсэн улсын төсвийн орлого 76.5 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 66.8 тэрбум, нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого 35.2 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцвэржүүлсэн орлого 21.0 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна.

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 4.1 хувь буюу 89.6 тэрбум төгрөгөөр буурч, төсвийн нийт зарлага 19.3 хувь буюу 380.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Төсвийн орлого өнгөрсөн оны мөн үеэс буурсан нь нэгдсэн төсвийн алдагдал өмнөх оны мөн үеэс өсөхөд нөлөөлжээ.

Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Хүснэгт 1.

	ӨО-ны мөн үеийн	2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл /тэрбум төгрөг/			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-306.4	224.9	198.7	88.4	-26.1
Засгийн газрын бонд	-31.2	-40.2	-40.8	101.6	-0.6
Засгийн газрын зээл	143.2	552.7	118.0	21.4	-434.6
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	478.8	0.0	0.0	-478.8
Өмч хувьчлал	0.06	0.4	0.06	15.3	0.3
НИЙТ ДҮН	-194.3	1,216.5	276.0	22.7	-940.5

Эх сурвалж: Сангийн яам

2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 200.2 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 40.8 тэрбум төгрөг, дотоод зээлийн үндсэн төлбөрт 36.1 тэрбум төгрөг тус тус төлжээ. Харин 80.1 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авч, Засгийн газрын урт болон богино хугацаат дотоод, гадаад бонд шинээр гаргаагүй байна.

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2,073.8 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 4.1 хувь буюу 89.6 тэрбум төгрөгөөр буурсан мөн тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 5.1 хувь буюу 111.1 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл Улсын төсөв 5.4 хувь буюу 76.5 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн төсөв 5.6 хувь буюу 35.2 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 16.6 хувь буюу 21.1 тэрбум төгрөгөөр, Орон нутгийн төсөв 7.8 хувь буюу 66.8 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрүүлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Орон нутгийн төсвийн орлого 19.2 хувь буюу 126.8 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн орлого 7.9 хувь буюу 43.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 10.6 хувь буюу 159.6 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 6.9 хувь буюу 7.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нэгдсэн төсвийн орлогын 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл, төсвийн шатлалаар


Хүснэгт 2.

/тэрбум төгрөг/

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,593.6	1495.7	854.0	787.2	630.7	595.5	126.7	105.7
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	32.2	6.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ИРЭЭДҮЙН ӨВ САН	139.9	144.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,421.4	1,344.9	854.0	787.2	630.7	595.5	126.7	105.7
Татварын орлого	1,134.9	1,158.9	325.2	294.2	475.7	440.5	126.7	105.7
Орлогын албан татвар	319.6	331.7	223.2	214.9	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	475.7	440.5	126.7	105.7
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	47.2	32.3	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	342.6	392.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	199.4	179.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	3.7	3.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	161.3	148.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	108.3	102.8	54.8	46.9	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	286.5	186.0	528.8	493.1	154.9	154.9	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	143.1	123.1	53.6	33.8	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.2	0.2	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	82.7	57.7	2.2	1.9	154.9	154.9	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	60.7	5.2	472.8	457.2	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

График 2. Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /хувиар/




Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 92.2 хувийг татварын орлого, 7.8 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 3.0 хувь буюу 58.9 тэрбум, татварын бус орлого 16.0 хувь буюу 30.7 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Татварын орлого 1,912.6 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 2.8 хувь буюу 54.3 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ.

Татварын орлогын 28.6 хувийг орлогын албан татвар, 24.0 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.7 хувийг хөрөнгийн албан татвар, 20.5 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 9.4 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 7.8 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 7.8 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

График 3. Татварын орлого /тэрбум төгрөг/



Тайлант хугацаанд зарим татварын орлогууд өссөн үзүүлэлттэй байна. Үүнд: нэмэгдсэн өртгийн албан татвар 14.6 хувь /50.1 тэрбум.төг/, орлогын албан татвар 0.7 хувь /3.9 тэрбум.төг/-иар өсчээ. Харин хөрөнгийн албан татвар 31.6 хувь /14.9 тэрбум.төг/, онцгой албан татвар 10.0 хувь /19.9 тэрбум.төг/, нийгмийн даатгалын орлого 9.3 хувь /47.3 тэрбум.төг/, гадаад үйл ажиллагааны орлого 7.8 хувь / 12.6 тэрбум.төг/, тусгай зориулалтын орлого 6.0 хувь /0.2 тэрбум.төг/-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.


Дутуу төвлөрсөн татварын орлогын 43.7 хувийг нийгмийн даатгалын орлого, 13.8 хувийг хөрөнгийн албан татвар, 18.4 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 11.7 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 12.3 хувийг бусад татвар, төлбөр хураамж эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр татварын орлого 58.9 тэрбум төгрөг буюу 3.0 хувиар буурахад онцгой албан татвар 34.0 тэрбум (15.9%), гадаад үйл ажиллагааны орлого 5.7 тэрбум (3.7%), тусгай зориулалтын орлого 0.7 тэрбум (17.1%), бусад татвар, төлбөр хураамж 64.0 тэрбум (29.9%) төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан татварын орлогын бууралтын 0.7 хувийг тусгай зориулалтын орлого, 5.5 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 61.3 хувийг бусад татвар төлбөр хураамж, 32.5 хувийг онцгой албан татвар тус тус эзэлжээ.

Татварын бус орлого 161.2 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 16.0 хувь буюу 30.7 тэрбум төгрөгөөр буурсан бөгөөд төлөвлөснөөс 56.8 тэрбум төгрөг буюу 26.1 хувиар дутуу төвлөрсөн байна.

Татварын бус орлого дутуу төвлөрөхөд газрын тосны орлого 30.9 тэрбум, гадаад хандив тусламжийн орлого 17.0 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 4.0 тэрбум, торгуулийн орлого 1.3 тэрбум, түрээсийн орлого 0.6 тэрбум, бусад орлого 9.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь голлон нөлөөлжээ. Харин хувьцааны ноогдол ашиг 0.5 тэрбум, хүүгийн орлого 6.2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлжээ.



Татварын бус орлогын 97.3 хувийг нийтлэг татварын бус орлого, 2.6 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийт татварын бус орлогод эзлэх нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 33.6 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 23.7 хувийг навигацийн орлого, 13.6 хувийг газрын тосны орлого, 10.0 хувийг хүүгийн орлого, 9.9 хувийг торгуулийн орлого, 0.4 хувийг хувьцааны ноогдол ашиг, 0.3 хувийг түрээсийн орлого, 8.5 хувийг бусад орлого тус тус эзэлж байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн дагуу нийт 18 төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсний 7 нь төлөвлөсөн орлогыг давуулан биелүүлсэн бол үлдсэн 11 нь 5.0-100.0 хувь дутуу төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй байна. Татварын ерөнхий газар 0.3 хувиар, Гаалийн ерөнхий газар 5,4 хувиар төлөвлөгөө дутуу биелүүлсэн үзүүлэлттэй байна.

2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр улсын төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого

Хүснэгт 3.

/сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	ӨО-ны	2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл			
	мөн үеийн	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сангийн сайд	1,283,453.2	1,532,326.3	1,480,901.5	51,424.8	96.6
Татварын ерөнхий газар	770,512.9	859,587.3	856,810.3	2,777.0	99.7
Үүнээс: Тогтворжуулалтын санд	65,725.1	32,240.0	6,469.4	25,770.6	20.1
Ирээдүйн өв санд	117,216.6	132,379.5	144,288.1	-11,908.6	109.0
Гаалийн ерөнхий газар	509,032.3	638,226.6	603,553.4	34,673.1	94.6
Сангийн яам	2,491.9	12,174.3	15,902.3	-3,728.0	130.6
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	210.8	21,169.4	3,642.4	17,526.9	17.2
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,205.3	1,168.7	992.9	175.8	85.0
Монгол Улсын Их Хурлын дарга	0.0	25.0	0.0	25.0	0.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	25.0	0.0	25.0	0.0
Монгол Улсын Ерөнхий сайд	1,247.5	2,071.3	3,150.4	-1,079.1	152.1
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	78.6	300.0	475.4	-175.4	158.5
Үүнээс: Ирээдүйн өв санд	0.0	0.0	0.0	0.0	0.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,168.9	1,771.3	2,675.1	-903.8	151.0
Монгол Улсын Шадар сайд	4,026.5	1,519.3	4,460.3	-2,941.1	293.6
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	778.1	962.5	525.0	437.5	54.5
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	3,248.4	556.8	3,935.4	-3,378.6	706.8
Хууль зүй, дотоод хэргийн сайд	11,080.2	12,796.2	10,761.5	2,034.7	84.1
Улсын бүртгэлийн ерөнхий газар	3,980.6	4,250.0	3,023.7	1,226.3	71.1
Цагдаагийн ерөнхий газар	407.0	1,310.0	280.9	1,029.1	21.4
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	1,397.6	2,616.0	2,274.8	341.2	87.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,295.0	4,620.3	5,182.2	-561.9	112.2
Гадаад харилцааны сайд	334.5	1,764.4	830.3	934.1	47.1
Дипломат төлөөлөгчийн газрууд	278.1	1,624.4	676.3	948.1	41.6
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	56.4	140.0	154.0	-14.0	110.0
Зам, тээврийн хөгжлийн сайд	39,840.3	38,804.0	38,963.7	-159.7	100.4
Иргэний нисэхийн ерөнхий газар	38,225.0	37,200.0	37,200.0	0.0	100.0
Зам, тээврийн хөгжлийн яам	54.3	54.0	54.0	0.0	100.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,561.0	1,550.0	1,709.7	-159.7	110.3
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	62,577.5	60,197.4	28,944.7	31,252.7	48.1
Ашигт малтмал, газрын тосны газар	62,358.5	60,039.3	28,620.1	31,419.2	47.7
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	219.0	158.1	324.6	-166.5	205.3
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	8,464.7	24,221.6	11,115.9	13,105.6	45.9
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	0.0	237.5	0.0	237.5	0.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	142.0	199.6	135.2	64.4	67.7
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	8,322.7	23,784.5	10,980.8	12,803.7	46.2
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	7,893.9	8,473.3	8,166.4	306.9	96.4

	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	7,893.9	8,473.3	8,166.4	306.9	96.4
Эрүүл мэндийн сайд		49,434.5	62,416.1	53,095.4	9,320.7	85.1
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	43,983.7	55,632.0	47,900.2	7,731.8	86.1
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,450.8	6,784.1	5,195.1	1,588.9	76.6
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд		54.0	29.2	100.1	-71.0	343.2
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	54.0	29.2	100.1	-71.0	343.2
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга		55.3	30.0	16.8	13.2	56.0
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	55.3	30.0	16.8	13.2	56.0
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд		1,255.5	1,661.8	559.4	1,102.3	33.7
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,255.5	1,661.8	559.4	1,102.3	33.7
Барилга, хот байгуулалтын сайд		0.0	508.0	185.0	323.0	36.4
	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	0.0	448.0	185.0	263.0	41.3
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	60.0	0.0	60.0	0.0
Батлан хамгаалахын сайд		6,995.9	3,771.9	8,635.3	-4,863.4	228.9
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	1,676.0	1,682.2	2,103.7	-421.5	125.1
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,320.0	2,089.7	6,531.6	-4,441.9	312.6
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга		56.8	30.0	58.9	-28.9	196.3
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	56.8	30.0	58.9	-28.9	196.3
Санхүүгийн зохицуулах хороо		10.0	179.1	518.3	-339.2	289.4
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	10.0	179.1	518.3	-339.2	289.4

Эх сурвалж: Сангийн яам

3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 3,401.5 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 69.1 хувийг ашиглаж 1,051.7 тэрбум төгрөг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 380.7 тэрбум төгрөг буюу 19.3 хувиар өссөн байна.

Нэгдсэн төсвийн зарлагын 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл /төсвийн шатлалаар/

Хүснэгт 4.

/тэрбум төгрөг/

	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,517.6	1,840.6	983.6	603.5	618.4	577.1	129.8	88.1
НИЙТ ЗАРЛАГА	2,550.9	1,866.4	967.1	601.5	618.4	577.1	129.8	88.1
УРСГАЛ ЗАРДАЛ	2,007.4	1,686.4	750.2	540.5	618.4	577.1	129.8	88.1
Бараа, ажил, үйлчилгээний зардал	750.0	540.4	604.7	483.1	7.0	6.1	1.4	0.7
Зээлийн үйлчилгээний төлбөр	192.9	185.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

Татаас	211.0	193.9	53.6	42.4	0.0	0.0	12.7	7.1
Урсгал шилжүүлэг	853.5	766.8	92.0	15.0	611.4	571.0	115.6	80.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	543.5	180.0	216.8	61.0	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-33.3	-25.7	16.5	2.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦЭЛ	-1,096.2	-495.7	-129.6	183.8	12.3	18.4	-3.0	17.6

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 684.5 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 365.6 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 41.3 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 41.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зарлага 303.9 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 94.1 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 83.6 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зардал 15.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 19.3 хувь буюу 380.7 тэрбум төгрөгөөр өсөхөд урсгал зардал 332.1 тэрбум, хөрөнгийн зардал 72.9 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Зээлийн үйлчилгээний төлбөр нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14.2 тэрбум төгрөг буюу 8.3 хувиар нэмэгдэж, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 7.6 тэрбум төгрөг буюу 3.9 хувиар буурсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл
/зардлын эдийн засгийн ангиллаар/

Хүснэгт 5.

/тэрбум төгрөг/


	ӨО-ны мөн үеийн	2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,969.1	3,401.5	2,349.8	69.1	-1,051.7
НИЙТ ЗАРЛАГА	1,968.5	3,418.2	2,373.5	69.4	-1,044.6
УРСГАЛ ЗАРДАЛ	1,800.5	2,657.8	2,132.6	80.2	-525.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	826.5	1,288.3	964.5	74.9	-323.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	531.5	673.3	620.9	92.2	-52.4
Үндсэн цалин	393.7	452.4	444.8	98.3	-7.6
Нэмэгдэл	101.8	165.1	133.8	81.0	-31.3
Унаа хоолны хөнгөлөлт	12.8	16.5	14.2	86.4	-2.2
Урамшуулал	16.0	31.1	21.0	67.5	-10.1
Гэрээт ажлын хөлс	7.1	8.2	7.1	86.6	-1.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54.5	74.7	65.8	88.1	8.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79.5	110.6	93.7	84.7	-16.9
Гэрэл, цахилгаан	13.2	17.6	15.7	89.1	-1.9
Түлш, халаалт	56.1	74.8	65.1	86.9	-9.8
Цэвэр, бохир ус	5.4	8.4	5.2	61.4	-3.3
Байрны түрээс	5.0	9.7	7.7	80.1	-1.9
Хангамж, бараа материалын зардал	27.0	53.1	35.1	66.2	-17.9
Бичиг хэрэг	2.5	4.2	2.9	69.3	-1.3
Тээвэр, шатахуун	10.2	23.7	14.5	60.9	-9.3

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2.7	4.1	3.0	71.7	-1.2
Ном, хэвлэл	0.3	1.3	0.5	37.0	-0.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9.1	14.7	11.2	76.4	-3.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2.2	5.0	3.1	62.0	-1.9
Нормативт зардал	52.0	93.9	46.5	49.5	-47.4
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24.5	34.1	23.5	69.0	-10.6
Хоол, хүнс	21.6	45.5	15.1	33.2	-30.3
Нормын хувцас, зөөлөн эдлэл	5.8	14.3	7.9	54.9	-6.5
Эд хогшил, урсгал засварын зардал	7.6	24.3	12.5	51.3	-11.8
Багаж, техник, хэрэгсэл	2.5	13.6	5.2	38.2	-8.4
Тавилга	0.5	0.7	0.7	98.1	0.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.1	1.4	0.7	51.7	-0.7
Урсгал засвар	4.4	8.6	5.8	68.2	-2.7
Томилолт, зочны зардал	5.0	6.6	4.8	72.3	-1.8
Гадаад албан томилолт	2.1	2.5	1.9	76.8	-0.6
Дотоод албан томилолт	2.3	3.0	1.9	63.4	-1.1
Зочин төлөөлөгч хүлээн авах	0.6	1.1	0.9	86.4	-0.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65.3	192.7	87.9	45.6	-104.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58.6	171.1	75.6	44.2	-95.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.7	2.0	0.9	47.8	-1.0
Даатгалын үйлчилгээ	2.9	6.3	5.8	91.8	-0.5
Тээврийн хэрэгслийн татвар	0.1	0.9	0.5	54.2	-0.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.1	0.1	0.0	15.2	-0.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1.3	6.6	2.1	30.9	-4.6
Газрын төлбөр	0.1	0.6	0.1	12.0	-0.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.5	0.9	0.4	46.8	-0.5
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1.1	4.2	2.5	59.7	-1.7
Бараа үйлчилгээний бусад зардал	58.6	133.9	63.1	47.2	-70.7
Бараа үйлчилгээний бусад зардал	51.7	119.5	56.6	47.4	-62.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6.9	14.3	6.5	45.5	-7.8
ХҮҮ	171.1	192.9	185.3	96.1	-7.6
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	122.4	152.3	144.7	95.0	-7.6
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	48.7	40.6	40.6	100.0	0.0
ТАТААС	52.1	122.4	88.5	72.3	-33.9
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	13.5	34.6	22.5	65.1	-12.1
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	38.6	87.8	66.0	75.2	-21.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	750.8	1,054.2	894.3	84.8	-159.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	15.1	62.9	29.2	46.5	-33.6
Засгийн газрын дотоод шилжүүлэг	13.6	61.1	27.5	45.0	-33.6
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1.5	1.7	1.7	100.0	0.0
Бусад урсгал шилжүүлэг	735.7	991.3	865.0	87.3	-126.3
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	487.3	610.9	570.8	93.4	-40.2
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	184.4	232.1	197.2	85.0	-34.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.9	1.6	0.8	51.8	-0.8
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20.2	98.5	59.3	60.2	-39.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30.2	32.8	26.5	81.0	-6.2
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх	10.7	10.9	8.4	77.2	-2.5
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1.8	4.4	2.0	44.0	-2.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	168.0	760.4	240.9	31.7	-519.4
Барилга байгууламж	122.1	488.4	164.1	33.6	-324.3

Их засвар	15.8	41.0	12.4	30.3	-28.6
Тоног төхөөрөмж	5.2	76.7	7.4	9.6	-69.3
Бусад хөрөнгө	22.1	140.2	48.2	34.4	-92.0
Стратегийн нөөц хөрөнгө	2.8	14.1	8.8	62.7	-5.3
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.6	-16.7	-23.7	142.1	-7.0
Эргэж төлөгдөх зээл	-6.0	-52.1	-31.2	59.9	20.9
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	6.5	35.4	7.5	21.1	-27.9

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувийн жин 89.9 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 1.6 пунктээр буурсан байна.



Нэгдсэн төсвийн нийт зарлагын 2,132.6 тэрбум төгрөг буюу 89.9 хувь нь урсгал зардал бөгөөд, нийт урсгал зардлын 45.2 хувийг бараа, ажил, үйлчилгээний зардал, 41.9 хувийг урсгал шилжүүлэг, 8.7 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 4.2 хувийг татаас эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 332.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: урсгал шилжүүлэг 143.5 тэрбум, бараа, үйлчилгээний зардал 138.0 тэрбум, татаас 36.4 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 14.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар 31 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр батлагдсан улсын төсвийн нийт зарлагын төсөв 677.0 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагджээ.

Улсын төсвийн нийт зарлагын 22.9 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 20.7 хувийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багц, 17.7 хувийг Сангийн сайдын багц, 9.2 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 8.0 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, 3.6 хувийг Зам, тээврийн хөгжлийн сайдын багц, 2.9 хувийг Батлан хамгаалахын сайдын багц, үлдэх 15.0 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын төсвийн зардал эзэлж байна.

Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Хүснэгт 6.

/сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл			
	Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	1,572.8	1,437.1	135.7	91.4
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	11,139.2	9,972.9	1,166.3	89.5
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	144,480.0	40,757.4	103,722.5	28.2

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	14,539.8	5,708.2	8,831.6	39.3
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	23,541.2	25,270.5	(1,729.2)	107.3
САНГИЙН САЙД	593,028.3	325,352.9	267,675.3	54.9
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	62,836.8	52,565.2	10,271.6	83.7
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	212,867.6	169,045.1	43,822.5	79.4
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	607.6	458.6	149.0	75.5
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	1,370.4	869.1	501.3	63.4
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	14,697.4	11,932.3	2,765.1	81.2
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	8,225.1	7,325.3	899.7	89.1
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	1,459.8	1,324.5	135.3	90.7
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	5,387.2	3,775.3	1,611.9	70.1
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	5,927.8	5,510.2	417.7	93.0
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	1,496.8	1,044.8	452.0	69.8
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	1,746.9	300.5	1,446.4	17.2
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА	49,022.2	38,071.5	10,950.7	77.7
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	45,613.9	34,531.5	11,082.5	75.7
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	5,300.4	259.4	5,041.0	4.9
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	305.2	265.1	40.2	86.8
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	5,714.4	4,131.7	1,582.7	72.3
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	48,222.1	22,322.5	25,899.7	46.3
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	171,369.1	147,207.6	24,161.5	85.9
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	32,194.8	20,139.7	12,055.1	62.6
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	441,397.4	381,020.6	60,376.8	86.3
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	70,967.5	65,408.3	5,559.2	92.2
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	3,170.9	2,933.5	237.4	92.5
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	33,495.1	28,968.1	4,527.0	86.5
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	19,496.4	11,359.8	8,136.6	71.6
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	486,208.2	421,368.3	64,839.8	86.7
НИЙТ ЗАРДАЛ	2,517,617.1	1,840,637.4	676,979.7	73.1

Эх сурвалж: Сангийн яам

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 212.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 103.8 тэрбум төгрөгийг зарцуулж 48.9 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

**МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН УЛСЫН ТӨСВИЙН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ /Сая төгрөгөөр/**

Хөрөнгө оруулалт	ТЕЗ	НИЙТ	Гүйцэтгэлийн хувь	
61,278.5	45,978.9	БСШУС-ын сайд	662,421.5	25.0
53,523.7	1727.1	ЗТХ-ийн сайд	310,979.8	96.8
27,243.9	10,564.4	БХБ-ын сайд	250,987.5	61.2
15,700.0	15,347.9	Сангийн сайд	175,100.0	2.2
14,514.3	1,799.4	ХЗДХ-ийн сайд	51,035.2	87.6
13,259.0	12,086.3	Эрүүл мэндийн сайд	133,756.2	8.8
8,099.1	7,076.9	Эрчим хүчний сайд	72,623.5	12.6
3,695.7	1,701.3	ЗГХЭГ-ын дарга	32,529.5	54.0
3,329.7	3,168.3	Монгол Улсын Ерөнхий сайд	23,459.0	4.8
2,920.0	2,496.7	Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд	25,456.9	14.5
2,424.5	378.9	Монгол Улсын Шадар сайд	9,934.9	84.4
2,150.0	2,041.0	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	25,426.8	5.1
1,891.1		Батлан хамгаалахын сайд	11,080.0	0
877.0		ХХААХҮ-ийн сайд	15,192.9	0
300.0		Улсын Ерөнхий прокурор	11,731.5	0
300.0		Гадаад харилцааны сайд	2,600.0	0
225.2		Авлигатай тэмцэх газрын дарга	1,120.7	0
200.0		Үндэсний Статистикийн хорооны дарга	650.7	0
100.4		Монгол Улсын Их Хурлын дарга	2,560.8	0
80.0		Монгол Улсын Ерөнхий Аудитор	1,000.0	0
0		Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч	4,480.0	0
0		Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	4,202.9	0
0		Үндсэн хуулийн цэцийн дарга	600.0	0
212,111.5	103,770.4		48.9%	
1 дүгээр улирлын санхүүжилт	Санхүүжүүлээгүй		1 дүгээр улирлын санхүүжилтийн хувь	

Эх сурвалж: Сангийн яам

“БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ” КОНЦЕССЫН ТӨРЛӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл

Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 108.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөж 49.8 тэрбум төгрөг буюу 46.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.




2020 оны 1 дүгээр улиралд 4 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 3 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Нийт олгосон санхүүжилтийн 64.2 хувийг Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто замын төсөл, 30.6 хувийг “Чойр” дэд станцын өргөтгөл, шинэчлэлийн төсөл, 5.2 хувийг Баянгол дүүргийн 38 дугаар сургуулийн барилгын төсөл, арга хэмжээ эзэлж байна.

Улсын Их Хурал, ХШҮ-ний хэлтэс,
Төсвийн шинжилгээний алба

Эх сурвалж: Сангийн яам


5. Нийгмийн даатгалын сан



Эх сурвалж: Сангийн яам

Нийгмийн даатгалын сангийн зарлагад 577.1 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 83.6 тэрбум төгрөг буюу 16.9 хувиар өссөн байна. Үүнд: Үүнд: Тэтгэврийн даатгалын сангийн зарлага 75.4 тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 8.2 тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 3.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, ҮОМШӨ-ий даатгалын сангийн зарлага 10.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.


График 6. Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын бүтэц



6. Эрүүл мэндийн даатгалын сан

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого:

График 7. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /тэрбум төгрөг/




Эрүүл мэндийн даатгалын санд 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 105.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төсөвлөснөөс 16.6 хувь буюу 21.1 тэрбум төгрөгөөр дутуу биелж, орлогын гүйцэтгэл 83.4 хувьтай гарчээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага:

2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 129.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 88.1 тэрбум төгрөгийг зарцуулж тус сангийн гүйцэтгэл 67.9 хувьтай гарчээ. Харин өнгөрсөн оны мөн үеэс тус сангийн нийт зарлага 15.8 тэрбум төгрөгөөр буюу 21.8 хувиар өссөн байна.

График 8. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /тэрбум төгрөг/




7. Орон нутгийн төсөв

2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 380.1 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 787.2 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн дүнгээс 7.8 хувь буюу 66.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

График 9. Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /хувиар/



Орон нутгийн төсвийн нийт орлогын 41.9 хувийг орон нутгийн төсвийн орлого, 47.8 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 9.0 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 1.3 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг эзэлж байна.

Орон нутгийн төсвийн нийт зарлага 603.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 38.6 хувь буюу 380.1 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсанаар орон нутгийн төсвийн тэнцэл 183.8 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 71.2 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон бол орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэгт 9.9 тэрбум төгрөгийг олгожээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 19.2 хувиар буюу 126.8 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн нийт зарлага 18.7 хувь буюу 94.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Орон нутгийн орлого төлөвлөснөөс 7.8 хувиар дутуу төвлөрөхөд орон нутгийн орлого 13.4 хувиар, санхүүгийн дэмжлэг 1.3 хувиар, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг 59.7 хувиар тус тус дутуу шилжсэнтэй холбоотой байна.

Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

Хүснэгт 7.

/сая төгрөг/

	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	4,778.0	4,778.0	100.0	13,672.8	13,672.8	100.0	634.3	394.1	62.1
Баян-Өлгий	2,709.5	2,709.5	100.0	18,226.3	18,226.3	100.0	859.4	535.7	62.3
Баянхонгор	6,853.3	6,853.3	100.0	13,162.9	13,162.9	100.0	926.3	415.3	44.8
Булган	1,637.2	1,637.2	100.0	8,754.4	8,754.4	100.0	470.8	245.6	52.2
Говьсүмбэр	817.3	817.3	100.0	2,310.6	2,310.6	100.0	156.4	58.2	37.2
Говь-Алтай	5,443.0	5,443.0	100.0	10,665.9	10,665.9	100.0	1,141.0	354.3	31.1
Дархан-Уул	0.0	0.0	0.0	11,471.6	11,471.6	100.0	854.5	318.6	37.3
Дорноговь	0.0	0.0	0.0	10,178.3	10,178.3	100.0	2,365.8	323.6	13.7
Дорнод	0.0	0.0	0.0	11,911.5	11,911.5	100.0	966.6	409.0	42.3
Дундговь	4,211.1	4,211.1	100.0	7,255.4	7,255.4	100.0	806.6	208.0	25.8
Завхан	6,851.8	6,851.8	100.0	12,245.0	12,245.0	100.0	602.4	356.8	59.2
Орхон	0.0	0.0	0.0	11,764.5	11,764.5	100.0	530.8	351.0	66.1

Өвөрхангай	6,032.3	6,032.3	100.0	15,041.4	15,041.4	100.0	723.4	459.8	63.6
Өмнөговь	0.0	0.0	0.0	7,008.2	7,008.2	100.0	2,255.8	352.5	15.6
Сүхбаатар	3,763.8	3,763.8	100.0	7,948.0	7,948.0	100.0	1,844.2	287.9	15.6
Сэлэнгэ	1,952.7	1,952.7	100.0	15,544.4	15,544.4	100.0	1,060.2	389.1	36.7
Төв	3,627.4	3,627.4	100.0	13,562.7	13,562.7	100.0	1,025.7	346.9	33.8
Увс	8,834.0	8,834.0	100.0	13,084.4	13,084.4	100.0	753.4	426.1	56.6
Улаанбаатар	0.0	0.0	0.0	129,564.0	129,564.0	100.0	3,372.3	2,302.5	68.3
Ховд	3,851.5	3,851.5	100.0	12,979.3	12,979.3	100.0	1,371.9	467.5	34.1
Хөвсгөл	6,261.7	5,311.7	84.8	17,939.5	17,939.5	100.0	906.8	601.0	66.3
Хэнтий	4,477.6	4,477.6	100.0	11,802.8	11,802.8	100.0	1,021.4	333.3	32.6
ДҮН	72,102.1	71,152.1	98.7	376,094.0	376,094.0	100.0	24,649.8	9,937.0	40.3

Эх сурвалж: Сангийн яам

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир зэрэг Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхэд нийт 376.1 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг аймгуудад олгожээ. Харин орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилахаар 24.6 тэрбум төгрөг төсөвлөсөн боловч 40.3 хувь буюу 9.9 тэрбум төгрөгийг шилжүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг аймгуудаар харуулбал; Архангай аймаг 94.0 сая, Баян-Өлгий аймаг 512.8 сая, Баянхонгор аймаг 1,119.4 сая, Говь-Алтай аймаг 1,487.5 сая, Дорноговь аймаг 6,066.0 сая, Дундговь аймаг 1,543.0 сая, Завхан аймаг 1,087.5 сая, Өвөрхангай аймаг 232.6 сая, Өмнөговь аймаг 1,996.6 сая, Сүхбаатар аймаг 2,936.4 сая, Сэлэнгэ аймаг 1,384.8 сая, Төв аймаг 1,004.9 сая, Ховд аймаг 1,276.6 сая, Хөвсгөл аймаг 615.8 сая, Хэнтий аймаг 6,864.5 сая, Дархан-Уул аймаг 922.8 сая, Улаанбаатар хот 41,415.5 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрүүлсэн байна.

Харин Булган аймаг 27.4 сая, Дорнод аймаг 556.2 сая, Увс аймаг 342.4 сая, Говьсүмбэр аймаг 870.0 сая, Орхон аймаг 1,994.8 сая, төгрөгөөр тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлжээ.

ДУГНЭЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд дараах дүгнэлт өгөхөөр байна. Үүнд:

Төсвийн орлогын хувьд: 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2,073.8 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 111.1 тэрбум төгрөгөөр дутуу биелж, өмнөх оны мөн үеэс 89.6 тэрбум төгрөг буюу 4.1 хувиар буурсан байна.

- Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө тайлант хугацаанд 5.1 хувиар дутуу биелэн 94.9 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөснөөс 111.1 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрөхөд татварын орлогын 2.8 хувь буюу 54.3 тэрбум төгрөг, татварын бус орлогын 26.1 хувь буюу 56.8 тэрбум төгрөгийн дутуу биелэлт нөлөөлжээ. Татварын орлогын хувьд төлөвлөснөөс орлогын албан татвар 3.9 тэрбум, нэмэгдсэн өртгийн албан татвар 50.1 тэрбум төгрөгөөр давж биелсэн боловч, нийгмийн даатгалын орлого 47.3 тэрбум, тусгай зориулалтын орлого 0.2 тэрбум, хөрөнгийн албан татвар

14.9 тэрбум, гадаад үйл ажиллагааны орлого 12.6 тэрбум, онцгой албан татвар 19.9 тэрбум, бусад татвар, төлбөр хураамж 13.4 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна.

- Татварын бус орлогын төлөвлөгөө 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 73.9 хувийн биелэлттэй гарч 56.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь тусламжийн орлого 17.0 тэрбум, газрын тосны орлого 30.9 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 4.0 тэрбум, торгуулийн орлого 1.3 тэрбум, түрээсийн орлого 0.6 тэрбум, бусад орлого 9.8 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 1,051.7 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 69.1 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад 30.6 хувиар дутуу зарцуулагдсан ч, өмнөх оноос 20.6 хувиар буюу 405.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 48.9 хувийн гүйцэтгэлтэй гарч, 103.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогджээ.
- Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үеэс 14.2 тэрбум төгрөгөөр буюу 8.3 хувиар нэмэгдэж, тайлант хугацаанд төлөвлөснөөс 7.6 тэрбум төгрөгөөр буюу 3.9 хувийн дутуу гүйцэтгэлийг үзүүлжээ.

---oOo---

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА